

БАТЛАВ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

С.МӨНХНАСАН

БАТЛАВ

“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ”
ХХК-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.АРИУНГЭРЭЛ

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ
ХХК-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
УЛААНБААТАР ХОТ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 он 09 сар 09 өдөр

Дугаар 35/21

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нэг талаас Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид “Захиалагч” гэх) түүнийг төлөөлж Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны дарга П.Ганболд, нөгөө талаас 5019877 тоот регистрийн дугаартай Монгол улсын хуулийн этгээд болох “Монголын үнэт цаас хэвлэл” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх) түүнийг төлөөлж Харилцагчийн зөвлөх У.Наранханд (цаашид хамтад нь “талууд” гэх) нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

1.2 Гүйцэтгэгч нь захиалагчийн ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгчийн материалыаар нисгэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны болон агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, дэвтэр хэвлэх (цаашид “Ажил” гэх)-ийг хавсралт 1-ийн дагуу тогтоосон хугацаанд хийж, гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгнө.

Хоёр. Төлбөр тооцоо

2.1 Гэрээний дагуу хийх ажлын хөлс 11,335,000 (Арван нэгэн сая гурван зуун гучин таван мянга) төгрөгийг ажлыг гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгсөнөөс хойш ажлын 5 хоногт багтаан ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн төлнө. Төлбөрийг дансаар шилжүүлж байгаа тохиолдолд тухайн ажлын өдрийн 17 цагаас өмнө хийгдсэн байна.

2.2. Энэ нь холбогдох татвар, хураамж болон захиалагчийн заасан газарт тээвэрлэн хүргэхтэй холбоотой бүхий л зардал багтсан эцсийн үнэ болно.

2.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд үнийн дүнд өөрчлөлт оруулахгүй.

Гурав. Гэрээний хугацаа

3.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх захиалгыг албан ёсоор хүлээн авч, эх загварыг захиалагчийн эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр баталгаажуулж өгснөөс хойш ажлыг



ажлын 7 хоногийн дотор гүйцэтгэнэ. Гэрээний хугацаа нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 30 хоног байна.

3.2 Талууд гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг энэхүү гэрээний хугацаа дуусахаас 5 өдрийн өмнө харилцан тохиролцож, шийдвэрлэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Захиалагч хэвлүүлэх бүтээгдэхүүний захиалгын хуудсыг батлагдсан эхийн хамт гүйцэтгэгчид өгч, хэвлэмэл бүтээгдэхүүний файлаа хэвлэлтэд оруулахаас өмнө гүйцэтгэгчийн гаргасан хар болон өнгөт загварыг сайтар хянан гарын үсгээр баталгаажуулна.

4.2. Гүйцэтгэгчийн ажлын явцын талаарх мэдээллийг авах, зааварчилгаа өгөх, хяналт тавих эрхтэй.

4.3. Гүйцэтгэсэн ажилд гэмтэл согог илэрвэл хүлээн авснаас хойш 5 өдрийн дотор гомдолын шаардлага гаргах эрхтэй.

4.4 Захиалсан бүтээгдэхүүний тоо хэмжээ дутсан, захиалагчийн шаардлагад нийцээгүй, чанарын шаардлагыг хангагүй, захиалагчийн өгсөн санал, зөвлөмжийн дагуу хийгдээгүй тохиолдолд гүйцэтгэгчид мэдэгдэж засварлуулсны дараа хүлээн авах эрхтэй. Цаашид харилцан тохиролцож ажлыг үргэлжлүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.

4.5. Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд нь хүлээн авах үүрэгтэй.

4.6. Гүйцэтгэсэн ажлын хөлсийг гэрээний дагуу хугацаанд нь ажил гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1 Захиалагчаас өгсөн хэвлэлтийн эхийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхгүй.

5.2 Гүйцэтгэгч эхэд өнгөт болон хар загвар гаргаж захиалагчаар хянуулан баталгаажуулна. Факс, и-мэйлээр явуулж болно.

5.3 Гүйцэтгэгч хэвлэлийн эхийг хүлээж авахдаа хэвлэлтийн технологиос шалтгаалан зайлшгүй хийх өөрчлөлтийг захиалагчтай зөвшилцэн хийнэ.

5.4. Гүйцэтгэгч хэвлэлийн эхэд зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулсан, өнгө нь зөрсөн, чанарын шаардлага хангахгүй гүйцэтгэсэн тохиолдолд алдаа доголдлыг ажлын 5-7 хоногийн дотор өөрийн зардлаар тухай бүрд нь арилган дахин гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.

5.5. Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх явцад захиалагчаас ирүүлсэн хэвлэлийн эх болон бусад мэдээллийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно. Ажил гүйцэтгэгч ийнхүү бусдад задруулсанаас захиалагч талд хохирол учирсан тохиололд хохирлыг бүрэн хариуцна.

5.6. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн бус буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй бол ажил гүйцэтгэхэд гарч буй саад бэрхшээлийн талаар захиалагчид нэн даруй мэдэгдэнэ.

Зургаа. Талуудын хариуцлага

6.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь гүйцэтгэлийн тодорхой хугацаа зааж бичгээр шаардлага тавих ба уг шаардлагыг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг буруутай тал хариуцна.

6.2 Гүйцэтгэгч захиалгыг цаг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх алданги төлнө.

6.3 Захиалагч төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,2%-тай тэнцэх алданги төлнө. Энэхүү алданги нь гэрээний 3.3-д заасан хадгалалтын хөлсөөс тусдаа тооцогдоно.

6.4 Талууд өөрийн буруутай үйлдлээс нөгөө талд хохирол учруулсан, нэмэлт ажил ба зардал гарсан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцах үүрэгтэй.

Долоо. Гэрээ цуцлах үндэслэл

7.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд захиалагч гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

7.1.1. Гүйцэтгэгч нь хэвлэлийн эх болон бусад мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр мэдээлэх, дамжуулах, тараах зэрэг захиалагчийн итгэлийг алдсан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан;

7.1.2. Гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ өөрөө биечлэн гүйцэтгээгүй буюу бусдад дур мэдэн шилжүүлсэн;

7.1.3. Гүйцэтгэгч захиалагчийн өгсөн зааварчилгааг удаа дараа зөрчсөн, гүйцэтгэсэн ажлын догоолдлыг захиалагчаас сануулсаар байтал санаатайгаар засварлаж, арилгаагүй;

7.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу гэрээнд харш үйл ажиллагаа явуулсны улмаас гэрээг цуцалсан бол гүйцэтгэгч ажлын хөлс шаардах эрхээ алдана.

7.3. Гэрээ цуцлах санал гаргасан тал түүнээс үүдэн гарах эрх зүйн үр дагаварыг бүрэн хариуцна.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Гэрээ нь талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

8.2. Энэхүү гэрээг талууд 3 (гурав) эх хувь үйлдсэн бөгөөд Захиалагч тал 2 (хоёр) эх хувь, Гүйцэтгэгч тал 1 (нэг) эх хувийг тус тус хадгална. Гэрээний хувиуд адиш хүчинтэй.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

9.1. Гэрээний хугацаа, нөхцөлийн талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

9.2. Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

9.3 Гэрээний хугацаа дуусахад талууд гэрээний хэрэгжилтийг дүгнэж, акт үйлдэнэ.

Арав. Бусад

10.1. Гэрээний аль нэг тал нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон тухай нотолгоог эрх бүхий байгууллагаас гаргуулан авч, нөгөө талд нэн даруй хүргүүлэн, холбогдох арга хэмжээг авна.

10.2. Энэхүү гэрээнээс үүссэн аливаа маргаантай асуудлыг хоёр тал зөвшилцлийн журмаар шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Гэрээ байгуулсан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА

П.ГАНБОЛД

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Д.ХАТАНБААТАР

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДҮРМИЙН
БОЛОВСРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

П.АРИУНБОЛД

ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ЗАЯА

Хаяг: Хан-Уул дүүрэг, 21-р хороо,

Бүянт-Ухаа

Утас: 71282253, 88116267

“МОНГОЛЫН ҮНЭТ ЦААС ХЭВЛЭЛ”
ХХК-ЫН ХАРИЛЦАГЧИЙН ЗӨВЛӨХ

У.Наранханд

У.НАРАНХАНД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



Э.АРИУНЦЭЦЭГ


Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо,

Ажилтны гудамж-135

Утас: 70140459, 80314444

e-mail: narankhand@msprint-mn

ИНЕГ
ХЯНААВ



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Гэрээний нэр	Ажил гүйцэтгэх гэрээ
Гэрээний танилцуулга	<p>Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсээс олгодог Иргэний нисэхийн ажилтны мэргэжлийн үнэмлэх болох Нисгэгч, Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх болон Нисгэгчийн нислэгийн дэвтрийн нөөц дуусаж байгаатай холбогдуулан ИНД-61 дүрмийн дагуу олгодог нисгэгчийн мэргэжлийн үнэмлэх 100 ширхэг, ИНД-65 дүрмийн дагуу олгодог нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх 100 ширхэг, ИНД-66 дүрмийн дагуу олгодог агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх 100 ширхэг, нисгэгчийн нислэгийн дэвтэр 150 ширхэг хэвлүүлэх ажлын шаардлага үүссэн. Иймд “Монголын үнэт цаас хэвлэл” ХХК-тай ажил гүйцэтгэх ажлын гэрээ байгуулах шаардлагатай байна.</p>
Газар, салбар, нээгжийн нэр	Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтэс
Огноо	2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Хянасан:
Албан тушаалтны нэр

 / Н.Заяа /

Боловсруулсан:
Мэргэжилтний нэр

 / Д.Туяацээг /

Жич: Танилцуулга нь хууль тогтоомжид нийцсэн, тооцоо судалгаанд тулгуурласан, мэргэжлийн төвшинд үндэслэл сайтай, товч тодорхой бичигдсэн байна.